



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 11 сарын 24 өдөр

Дугаар 581

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Харилцаа холбооны зохицуулах хорооны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 3 нэрийн нийт 67,466,120.57 (жаран долоон сая дөрвөн зуун жаран зургаан мянга нэг зуун хорин төгрөг тавин долоон мөнгө) төгрөгийн балансын үнэ, 11,772,689.10 (арван нэгэн сая долоон зуун далан хоёр мянга зургаан зуун наян есөн төгрөг арван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга Г.Чинзориг, “МИАТ” хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Баттөр, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Захиргаа удирдлагын албаны дарга Н.Ганболд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг хүлээлцэх, балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.


3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 11 дүгээр сарын 24 ны өдрийн
581 дугаар тогтоолын хавсралт

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтанд орсон он	Балансын үнэ	Хуриятлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэн авах хуулийн этгээд
				(төгрөг)		
1	Хьюндай Соната 6, 10-62 УБЯ, КМНЕТ41АР9А535555	2008/2008	4,452,189.07	1,855,078.80	2,597,110.27	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
2	Хьюндай Соната 6, 10-67 УНУ, КМНЕТ41АР9А617393	2008/2008	4,196,431.50	1,748,513.10	2,447,918.40	
3	Ланд Крузер 200, 25-70 УБН, JTMNH05J404024455	2012/2012	58,817,500.00	8,169,097.22	50,648,402.78	"МИАТ" ХХК
Нийт дүн				11,772,689.12	55,693,431.45	-
				(арван нэгэн сая долоон зуун далан хоёр мянга зургаан зуун наян есөн төгрөг арван хоёр мөнгө)	(тавин таван сая зургаан зуун ерэн гурван мянга дөрвөн зуун гучин нэгэн төгрөг дөчин таван мөнгө)	